

ХАРХОРУМ ХОТЫГ МАЛТАН ШИНЖИЛЖ БАЙГАА НЬ

Х. ЛХАГВАСҮРЭН

Манай оронд археологийн шинжлэх ухаан амжилттай хөгжиж тус орны нутаг дэвсгэрээс эрт, дундад үеийн 300 гаруй хот суурины үлдэгдлийг илрүүлэн судалгаа шинжилгээний ажлуудыг хийсээр байгаа билээ. Эдгээрийн дотор XIII зууны монгол гүрний нийслэл байсан Хархорум хотын үлдэгдлийг малтан шинжлэх ажил чухал байр эзэлнэ. Хархорумын судалгааны үр дүн нь хэмжээний хувьд олон арван бүтээлүүд болохоор байгаа бөгөөд энэ удаа бид зарим нэг эрдэм шинжилгээний сонирхолтой материалуудыг хөндөн бичихийг эрмэлзлээ.

ШУА-ийн түүхийн хүрээлэнгээс зохион явуулсан Хархорум хотыг судлан шинжлэх анги, юуны өмнө уг хотын дэвсгэр зургийг бүрэн хэмжээгээр зурж, малталт явуулж, мөн ойр орчимд нь байгаа бусад дурсгалуудыг малтан шинжилж тодорхойлох ажлыг хийхдээ Хархорум хотыг дөрвөлжин ухах аргыг малтлагын үндсэн хэрэглүүр болгон гүйцэтгэсэн билээ. Ийнхүү ажиллахдаа хотын нийт талбайг 1 м x 1 м, 2 м x 2 м гэх мэт хэмжээтэй олон тооны дөрвөлжингүүд болгон малтлагыг явууллаа. Малтлагын ажил явагдаж буй үед Парис хотноо болж өнгөрсөн ЮНЕСКО гийн экспертүүдийн хуралдаанаас гаргасан төгсгөлийн баримт бичигт «Төв Азийн түүх» хэмээх 6 боть номыг зохиоход шаардагдах гол бэлтгэл ажлын нэг нь Хархорум хотыг малтан судлах явдал гэж заасан нь өгүүлэн буй хотын судалгааг эрчимжүүлэхэд чухал түлхэц болсон юм. Цаашдын малтлагаар соёлт давхаргын дээд хэсгээс олдсон өрөөстэй хэсэг тоосгоны наалдсан байдлаас үзэхэд тоосгыг цохойн зуурмагаар шавардан наалдуулж тогтоосон байна.

Тосгуур ваарны нүүрний хээнүүд өөр боловч хэмжээ болоод ерөнхий хэлбэр дүрс, нэгэн ижил байсны гадна ЗХУ-ын нутагт малтан шинжилсэн монгол гүрний үед холбогдох Даян дээрхийн хотоос олдсон барилгын материалтай адилтгах тал ажиглагдаж байна.¹

Түүнчлэн ургамал болон амьтны дүрстэй хээ бүхий үзэсгэлэнтэй сайхан том тавагнууд бүтнээрээ илэрсэн нь урд өмнө Хархорум хотыг малтан шинжлэхэд олдоогүйгээрээ онцлог юм. Уг таваг нь гар үйлдвэрлэлийн ажил тухайн үед Хархорум хотод ихэд өрнөж байсны гэрч бөгөөд тоосго өрж, шатаасан ваараар дээвэрлэсэн хэрмийн хананы хэсэг, шавар сав эдлэл шатаадаг байсан бололтой зуух зэрэг нь бидний объект 1 гэж нэрлэсэн малтлагын хэсгээс олдсон юм. Амсар хэсгээрээ 29 см, ёроолоо роо 21 см, 4 см өндөртэй өрөвтасын зураг зурж, түүний дээд, доод талд нь нэг нэг том цэцэг, баруун зүүн хоёр талд нь усанд хөвж буй нугасны зураг дүрсэлсэн байх ба элдэв цэцэг навчсын зурагтай таваг бас гарчээ. Тэрчлэн амсараараа ялихгүй гадагш эргэсэн, цөгцөн ёроолтой, бөөрөнхий бөөртэй том аяга олдсон ба аяганы ирмэг нь долгион хэлбэртэй, ургамлын хэлбэртэй, угалз хээтэй байжээ.

Дорно дахины орнуудын их хаадын ордны дээврийг улаан ногоон паалантай тоосгоор дээвэрлэдэг заншлыг мөрдлөг болгон хэрэглэж байсан улаан ногоон паалангийн хагархайнууд Өгэдэйн ордыг малтахад олноороо олдсон юм. Мөн луу болон өөр амьтадыг дүрсэлсэн шавар эдлэ-

1. С. В. Киселев и другие Древнемонгольские города, М., 1965 с 92

лүүд илэрсэн нь дээврийг элдэв амьтдын дүрсээр чимэглэсний илрэл билээ. Хархорум хотын малтлагын явцад ихэд олдож байгаа барилгын хэрэглэгдэхүүн бол туйпуунууд юм. Туйпууны дээр дугуй хүрээ бүхий хас, загалмай буюу хэрээс тэмдэг, Ж үсэг, янгирын дүрс мэт тамга тэмдгүүдийг хийсний зэрэгцээ нэгэн туйпууны дээр дөрвөлжин тор маягийн хээг хурц үзүүртэй зүйлээр дүрсэлсэн байв. Ийнхүү хийхдээ нэгдүгээрт, гадаргуу дээр нь товойлгон гаргаж, хоёрдугаарт, хонхойлгон дүрслэх маягаар хийсэн байлаа. Дээрх олдворын хийц нь монгол гүрний үеийн уран барилгын хөгжлийг аль нэг хэмжээгээр харуулахуйц ач холбогдолтой болно.

Дундад зууны монголчуудын улс төрийн гадаад харилцааг судлахад сонирхолтой жишээ болох Египетийн фараон (хаад)-ын хэвд цутгаж хийсэн хөрөг, араб зоос зэрэг эд өлөг малтлагын явцад анх олдлоо. Дээрх хөрөг нь 15 см урт, хойт талдаа ямар нэг юманд хадаж бэхлэж байсан шинж бүхий бөгөөд нүд томтой, хамрын хянга нь намхавтар, зузаан уруултай нэгэн хүнийг дүрсэлсэн байлаа. Уг хөргийг хэвд цутгаж хийхдээ банзыг ашигласны ором үлдсэн байсан бөгөөд энэ нь хар, эсвэл нарс модны ширхгийн байдал төрхийг хадгалсан байв. Иймд хөргийг хаана бүтээв, яагаад эмэгтэй хүний оршуулганд байна вэ? гэх зэрэг олон асуудал урган гарч байгаа ба Египетэд дээр дурдсан мод байхгүй бөгөөд харин манай орны хувьд элбэг. Гэвч хэвийг нь хаанаас авчирсан гэдэг өөр нэг асуудал бий. Дундад зууны үед Монголчууд Египеттэй холбоотой байсан олон баримт байдаг.

Алтан ордны улс Египетийн хооронд элчийн харилцаа XIII зууны 2-р хагасаас XIV зууныг дуустал үргэлжилж байсан² бол, Иль хаад Сири, Палестинийг байлдан дагуулахын төлөө Египетийн мамлюкийн султангуудтай дайтаж байжээ.³

Хархорум хотыг малтан шинжлэх хээрийн шинжилгээний анги 1984 онд 20 см гүнээс хятад бичигтэй боржин чулуун хөшөөний хэлтэрхий олжээ. Энэ нь нийт 14 үсэгтэй ба өндөр нь 12 см, өргөн нь 23 см, зузаан нь 13 см байжээ. Хэлтэрхийгээс үзэхэд энэ нь маш том хөшөөний хэсэг болох нь илт ажээ. Хэлтэрхий дээр зүүн гар талд бичсэн 4 үсэг бүхий нэг мөрнөөс дараагийн мөр хүртэл хоорондоо 5 см зайтай, харин 4 үсэгтэй 2 дахь мөр тус бүр 3 үсэгтэй бөгөөд 3 ба 4 дэх мөрүүд нь хоорондоо 1 см зайтай байжээ. Уг бичээсний эхний мөр нь хөшөөний гарчиг буюу толгойн бичээс, харин 2, 3, 4-р мөр нь энгийн бичээс бололтой. Эл байдлаас энэ хөшөө нь мөр даран бичсэн (парчиг) толгой бүхий томоохон бичигтэй хөшөө байжээ. Хөшөөний хэлтэрхий Өгэдэй хааны ордны үүдэвч барилгын үлдэгдлийн зүүн өмнөхөн байгаа мэлхий чулуу наас 24 м зайтай газраас олсон зэргээс тэр нь анх мэлхий чулууны нуруун дээр байсан том хөшөөний хэсэг байж гэхэд үгүй гэх газаргүй.⁴

Сүүлийн жилүүдэд өгүүлэн буй хотыг малтах ажил тасралтгүй явагдаж 1983 онд 34 см урт, 2 м өргөн талбайг хамарсан малтлагыг 7-р сард хийхэд соёлт хөрс нь хамгийн нам хэсэгтээ 20 см, өндөр талдаа 1 м 45 см байсан бөгөөд 8-р сард 2 м өргөн, 25 м урт хэсгийг хамарч 2 дахь малтлагын ажлыг хийсэн юм.

Монголд байсан эрт дундад, үеийн хот суурины нэгэн сонирхолтой тал нь урьд мандаж хөгжсөн улсын хот сууриныг дараа товойн гарсан улс

2. В. Т. Тизенгаузен. Сборник материалов относящихся к истории Золотой Орды, т, 1, СПб, 1884, стр. 55, 58, 59

3. Татаро Монголы в Азий и Европе М., 1977, стр 237.

4. Хархорум хотыг малтан шинжлэх хээрийн шинжилгээний ангийн тайлан, 1984 он. 4—5-р тал

нь залгамжилж цааш нь хөгжүүлж байсан удаа байдаггүй, харин дайсагнан үзэж элдэлж орхидог байсан бололтой. Тийм учраас Хархорумыг эс оролцуулбал эрт, дундад үед манай оронд (олон зуун жилд нэг ул саас нөгөө улсад уламжилсан олон наст хуучин хот үлдсэнгүй⁵ буюу үлдсэн ч цөөхөн байж болох юм.

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутагт орших Хархул хааны балгасыг 1984 — 1986 онуудад шинжилсэн малтлага нь уг хот хоёр улсын үе дамжсан олон настай дурсгал болохыг харуулсан билээ. Иймд сүүлийн жилүүдэд дээр дурдсан Хархул хааны балгасыг Хархорум хотыг малтах ажилтай хослуулан хийж судалгааны хэрэглэгдэхүүнийг харьцуулах ажлыг гүйцэтгэсэн юм. Тэрчилэн Хархорум хотын дүүрэгт хойноос урагш 1600 м урт, өргөн нь 1200 м, 600 м орчим хотын талбайг хойноос урагш огтолсон гудамжтай байгууламжийг шинжилсэн ба энэхүү хот нь гадуураа зөв бус 4 өнцөгт хэлбэрийн шороон хэрмээр хүрээлэгдэж хотын талбайн зүүн хэсгээр огтолж гарсан 2 их гудамжтай байсныг дээрх баримт тодруулж өгсөн билээ. Уг хотын малтлагын ажлын явцад Хархорумын хүн амын бүрэлдэхүүнийг харуулахуйц булш оршуулгууд олноор илэрснийг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал, оршуулгын зан үйл болон антропологийн хэв шинжээрээ дундад зууны монголчуудаас ихээхэн ялгаатай 40 орчим булш оршуулгыг хотын зүүн хойт хэсгээс илрүүлсэн. Энд нас барагчаа дээш харуулан хэвтүүлж, толгойг нь умар зүг чиглүүлэн нүүрийг нь баруун тийш харуулж оршуулсан байв. Зарим булшинд бол бага зэрэг хажуулдуулан хоёр хөлийг өвдгөөр нь нугалан тавьсан байжээ. Эндэхийн бүх оршуулга бүгд гадуураа модон австай, банзаар дөрвөлжин хүрээ хийж ёроол хийлгүй газарт тавиад дээрээс нь хөндлөн банз зэрэгцүүлэн тагласан ажээ. Ихэнхдээ оршуулганд хүндээ дагалдуулсан эд өлөг гараагүй, 29-р булшинд модон авсны гадуур түүхий туйпуугаар бунхан барьсан тохиолдол олдсон байна. Харин 21-р булшинд жижиг хүүхдийн ташаа орчимд нь тахианы өндөг 2 ширхэгийг дагалдуулсан байв. Бас 23-р булшинд нас барсан хүний толгой дор нь том тоосгоор дэр хийсэн, 29-р булшны дотор насан өөд бологчийнхоо хүйс хавилдаа ямар нэг даавуун эдлэл тавьж, хоёр гарыг нь тохойгоор нь нугалан зөрүүлж тавьсан зэрэг нь оршуулгын зан үйлийн хувьд сонирхолтой баримт болсон юм. Уг оршуулгыг үлдээсэн нүүдэлчид XIII зууны дундад Ази, тухайлбал Семиречийн хавьд иргэншиж байсан нүүдэлчидтэй угсаа гарвалын холбоотой байж⁶ болохыг Хархорумын дээрх булшнаас гарсан палеоантропологийн олдворын харьцуулсан судалгаа харуулжээ.⁷ Хархорум хотын шинжилгээний анги нь дурдан байгаа хотыг судлахын зэрэгцээ бусад археологийн дурсгал түүний дотроос дундад зууны монголчуудын булш оршуулгыг малтах ажил хийсэн билээ.

Шинжилгээний ажлын явцад Хархорум хотын хэрмээс баруун урагш, бензин түгээгүүрийн салбарын зүүн талд 100 орчим метр зайд нэгэн оршуулгыг малтаж 2м50 см гүнээс 183 см урт модон авсанд хийж оршуулсан оршуулга олжээ. Авсны баруун дээд өнцөгт нь том амсартай ваар саванд хийж тавьсан нас бие гүйцсэн хүний чандар олсон бөгөөд, чандарын хамт хүний шатаагдаагүй шүднүүд гарчээ. Эндээс мөн үсний гурван хавчаар, чих, хумс цэвэрлэдэг байрын халбага хэлбэрийн жижиг эдлэл, 14 см урт, 1,1 см өргөн могой хэлбэрийн гаж дүрст амьтны алт шармал

5. Х. Пэрлээ, Монгол ард улсын , эрт, дундад үеийн хот суурны товчоон УБ., 1961, 6-р хуудас

6. Д. Түмэн. Палеоантропологический материал. Монгольского времени из Хархорина. S. A, T. 11. F, 8, с. 97

7. Хархорумын шинжилгээний ангийн тайлан, 1975—1978 он.

хүрэл хатгуур, голоороо зүсмэл нимгэн хавтгай туузыг тахийлган хийсэн цагаан өнгөтэй 10,6 см урт, 1 см өргөн чимэглэл зэрэг олдворууд илэрсэн байна. Өөр нэг булшийг Эрдэнэ зуу хийдийн баруун хойно, Ханджамц хатны суврагаас баруун тийш 5 м орчим диаметртэй байсныг малтахад 150 см өндөр хүнийг авсгүй оршуулж зүүн өвдөгний хавьд дугуй цэцэг хэлбэртэй, голдоо нүхтэй хүрэл чимэглэл, зэрүүлийн таваг, үйсний хэсэг дагалдуулсан байжээ. Түүнчлэн Хархорумын САА-н төвд ойн аж ахуйн барилга баригдаж байгаа тэгш талбайд 4 м орчим голточтой оршуулгыг малтахад 15 см гүнээс эхлэн шатсан зүйлийн жижиг үлдэгдэл гарсан байна.⁸ Ийнхүү чандарлаж оршуулсан оршуулгууд Хархорумын дүүргээс олдсоор байгаа нь дундад зууны үед оршуулгын ийм хэлбэр Монгол оронд байсан гэж үзэх үндэстэйг харуулж байна. Хархорумаас илэрсэн олдворууд нь тухайн үеийн түүхийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болж байгаа юм. Цаашид Монгол орон дахь суурин амьдрал болон, суурьшмал, нүүдлийн элементийг хослуулан судлах хэрэгтэй байна.

Тухайн үед Монгол оронд ирж байсан жуулчдын тэмдэглэлд Хархорум хотод олон тооны харийн хүмүүсийн амьдран сууж байсан тухай дурдсан байдаг.⁹ Түүнийг эдгээр оршуулгууд бодитойгоор харуулж байгаагаараа судалгааны ач холбогдолтой юм.

8. Мөн тайлан

9. Путешествие восточные страны Плано Карпини Рубрука. М. 1957, стр 160, 164, 165